

Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 2017 онд төсвийн 212 байгууллагын 23605 албан хаагчид, хувийн хэвшлийн 3742 аж ахуй нэгжийн 67564 албан хаагчид, сайн дурын 11777 иргэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна. Эрүүл мэндийн даатгалд 58111 иргэн хамрагдсан. Үүнээс төр эрүүл мэндийн даатгалыг хариуцсан даатгуулагч 39784 байна. 2017 оны гүйцэтгэлээр Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 102.4 хувиар биелүүлж, 201.5 тэрбум төгрөг хуримтлуулсан байна. Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 61.2 хувийг тэтгэврийн даатгалын санд, 7.4 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 20.0 хувийг эрүүл мэндийн даатгалын санд, 9.7 хувийг ҮОМШӨ-ийн даатгалын санд, 1.7 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Нийгмийн даатгалын үндсэн үзүүлэлтүүд, сая.төг

Үзүүлэлтүүд	2012	2013	2014	2015	2016	2017
Сангийн орлого	130549.2	136249.8	153246.0	159524.0	174385.1	201551.9
Сангийн зарлага	48141.3	57252.8	68373.4	79825.5	87839.1	92913.9
Ажил олгогчдын тоо	2771	3289	3649	3841	4072	3969
Даатгуулагчдын тоо	91777	100242	107353	90624	93584	90565
Сайн дурын даатгуулагчдын тоо	7357	9905	12437	13351	12595	11869
Тэтгэвэр авагчдын тоо	16453	16908	18235	20596	19723	20443
Олгосон тэтгэврийн хэмжээ	43023.30	49314.3	56312.4	68251.1	74645.6	80293.2
Өндөр насны тэтгэвэр	35028.59	40938.4	48 043.9	56775.0	63157.4	60949.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр	5581.8	5338.9	7 490.45	7780.9	8750.7	8084.9
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	2269.4	2138.0	2 635.8	2744.9	2737.6	2685.5
Тэтгэмж олголт	5041.20	7802.7	10 024.9	11554.2	12900.6	12241.7
хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	815.9	1073.7	1 212.6	1336.2	1523	1748.8
жирэмсэн амаржсаны тэтгэмж	3705.7	5715.3	7 416.43	8476.1	8873.8	8375.5
Оршуулгын тэтгэмж	10.5	9.15	46.14	32.2	55.2	61.1
Рашаан сувиллын хувьсах зардал	6.5	6.09	4.02	65.5	4.7	4.3
Ажилгүйдлийн тэтгэмж	502.2	994.6	1 308.0	1644.2	2371.2	2035.1
Сургалтын төлбөр	0.3	0.5	-	-	-	-

Зураг 1. 2017 онд Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлсэн хүний тоо




2017 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 201.5 тэрбум төгрөгт хүрсэнийг ноднингийн мөн үетэй харьцуулан авч үзвэл 27166.8 сая төгрөгөөр буюу 15.5 хувиар өссөн дүнтэй гарсан байна.


Хүснэгт 2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлт, сая.төг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт %
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	120089.95	123968.12	103.22
Тэтгэмжийн сангийн орлого	14906.35	16204.64	108.70
ҮОМШӨ-ний даатгалын орлого	19126.27	18440.60	96.41
Ажилгүйдлын даатгалын сангийн орлого	3469.05	3312.03	95.47
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	39334.86	39626.50	100.74
НИЙТ	196926.48	201551.89	105.35

Зураг 2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвөгөөний биелэлт сан тус бүрээр, хувиар



Зураг 3. Нийгмийн даатгалын сангийн орлого, зардал, сая.төг



Нийт олгосон тэтгэвэрийн 75.9 хувийг өндөр насны, 10.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.3 хувийг тэжээгчээ алдсаны, 9.5 хувийг цэргийн, 1.2 хувийг ҮОМШӨ-ий тэтгэвэрт тус тус зарцуулсан байна.


Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, сая.төг

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт олгосон тэтгэврийн хэмжээ	43023.3	49314.3	56312.4	68251.1	74645.6	80293.2
Үүнээс :						
Өндөр настан	30269.9	34926.5	41956.1	50063.0	74645.6	60949.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	4744.2	5338.9	6517	7780.9	7932.6	8084.0
Тэжээгчээ алдсан	1980.5	2138	394.7	2744.9	2621.8	2685.4
Цэргийн	2527.4	5221.2	6011.7	6540.2	6712.0	7643.5
ҮОМШӨ	535.4	807.5	899.2	904.4	950.3	930.5

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт тэтгэвэр авагчдын тоо	16453	16908	18235	20596	19723	20443
Үүнээс:						
Өндөр настан	11723	12956	15054	14455	15054	15152
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	2652	2852	3117	2888	3117	2888
Тэжээгчээ алдсан	1022	951	955	932	955	950
Цэргийн	1247	1282	1296	1269	1251	1266
ҮОМШӨ	243	229	210	201	197	187

Зураг 4. Нийгмийн даатгалын сангаас 2017 онд тэтгэвэр авагчдын тоо, хувиар



2016 онд Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн 74.1 хувийг өндөр настан, 14.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 6.2 хувийг цэргийн, 4.6 хувийг тэжээгчээ алдсан, 1.0 хувийг ҮОМШӨ-ний тус тус эзэлж байна. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо нь жил ирэх тусам нэмэгдэж байна.

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ:

www.1212.mn

www.UBSTAT.mn

WWW.CHINHGEI.TEI.GOV.MN

